

БНХАУ ДАХЬ МОНГОЛЫН СУДЛАЛ, ТҮҮНИЙ ЗОРИЛГО**Б. Цэдэндамба**

50-иад оны эхээр ХКН-ын дотор марксист-ленинист, интернационалч хүч давамгайлж байсан үед Монгол судлалын ажлыг монголчуудын үндсэн эрх ашгийн үүднээс өвөр монголчуудын түүхийг бодитой бичих чиглэл нэлээд хөгжиж болох төлөвтэй байв. Гэвч тэр үед хятад дахь Монгол судлаачдын дотор бас монголын судалгааг ХКН-ын үндэсний бодлоготой нягт холбон судлах, ялангуяа монголчууд бол хэзээнээс нааш хятадын салшгүй хэсэг гэдгийг нотлоход зориулах гэсэн чиглэл бас байсан юм. Нэгдүгээр чиглэлийг баримтлагсад нь 1958 оны үед үндсэндээ хэлмэгдэж дууссанаар хоёрдугаар чиглэлийн санаа давамгайлан одоо хүртэл үргэлжилсээр байна.

БНХАУ байгуулагдсаны дараа Хятад дахь Монгол судлалын ажил нь голцуу Хятадын ШУА-ийн дэргэдэх хятад биш ард түмний судлалын төвийн Монгол судлалын групп, Бээжингийн Их Сургуулийн монгол хэлний анги, үндэсний дээд сургуулийн монгол хэл түүхийн анги, Үндэсний хэвлэлийн хороо болон Өвөр Монголд төвлөрч байв. 1956 онд БХАТХ-ын Байнгын хорооны дэргэд байгуулагдсан Үндэстний комиссоос тусгай судалгааны групп бүрэлдүүлэн Өвөр Монголын нийгэм, түүхийн судалгааг зохион явуулсан байна.¹ Өвөр Монголын өөртөө засах оронд Монголын түүх судлах хүрээлэн, хэл уран зохиолын хүрээлэн байгуулагджээ. 1957 онд нээгдсэн Өвөр Монголын Их сургуулийн дэргэд Монголын түүх судлах тасаг, хэл уран зохиол судлах тасаг зэрэг тусгай эрдэм шинжилгээний байгууллагууд бий болж, монгол судлалын ажлыг шууд эрхлэж зохион байгуулалтын хувьд нэлээд бэхжих төлөвтэй болж байжээ.

1954 оноос ӨМӨЗО-д «Монгол хэл бичиг» хэмээх эрдэм шинжилгээний хялбарчилсан сэтгүүл монгол хэлээр гарч эхэлсэн нь Монголын судлалыг, ялангуяа хэл бичгийн судлалын ажлыг хөгжүүлэхэд бага бус үүрэг гүйцэтгэж байжээ. Тэр үед Монголыг судлагч монгол, хятад, эрдэмтэд хятад-монгол толь бичиг зохиох, монгол хэлний нэр томъёо боловсруулах, монгол хэлний орон нутгийн аялгуу судлах зэрэг ажлыг хийж тэр чиглэлээрээ эрдэм шинжилгээний чанартай өгүүллүүд нийтэлж байв. Монгол судлалын ажлын хүрээ жилээс жилд өргөжиж ирснийг харгалзан «Монгол хэл бичиг» сэтгүүлийн нэрийг өөрчлөн

¹ Үүний үндсэн дээр «Монгол үндэстний товч түүх» дагуур, эвенк, орчон хятад биш үндэстний түүхийг дотоодын хэрэгцээнд зориулан зохиожээ.

«Монгол хэл, зохиол, түүх» сэтгүүл болгож сар тутам гарах болжээ. ӨМӨЗО-ы эрдэм шинжилгээний ажилтнууд монгол хэл, утга зохиол түүхийн талаар хийсэн судалгааныхаа үр дүнгээс гадна ЗХУ, БНМАУ-ын эрдэмтдийн бүтээлээс нийтэлдэг болсон нь тухайн үедээ л сэтгүүлийн нэр хүндийг ихэд дээшлүүлсэн бөгөөд БНХАУ-ын дотор төдийгүй дэлхийн олон орны монголч эрдэмтдийн захиалан үздэг хэвлэлийн нэг болгосон байна.

Мөн түүнчлэн хятад, өвөр монголын судлаачид нийт Монголын ба Өвөр Монголын түүхийн асуудлыг хөндсөн «Өвөр Монголын хөгжлийн төлөв», «Өвөр Монголын түүхийн товч найруулал», «Умард Ди ба Хүннү», «Ухуань, Сяньби нар», «Киданы нийгэм-эдийн засгийн түүх», «Мин улсын Ойрадтай байлдсан нь», «Чингэс хааны намтар» зэрэг түүхийн ном, товхимолуудыг бичиж хэвлүүлжээ. Түүнээс гадна монгол - зөвлөлтийн түүхчдийн хамтын бүтээл «БНМАУ-ын түүх» хэмээх нэг боть зохиол, Х. Чойбалсангийн Монгол ардын хувьсгалын товч түүх болон И. Я. Златкины «БНМАУ бол шинэ ардчиллын орон мөн» номнуудыг орчуулан хэвлэжээ.

БНМАУ, БНХАУ-ын хоорондын соёлын хэлэлцээрээр багш, оюутан, аспирант солилцож байв. БНМАУ-ын түүхийн 3 боть зохиох ажилд монгол, зөвлөлтийн эрдэмтэдтэй хамт хятадын түүхчид оролцохоор хэлэлцэн тохиролцож группийн хурал зөвлөлгөөнд оролцож байсан боловч сүүлдээ шууд татгалзжээ. Улаанбаатар хотод хуралдсан олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд хятадын монголч эрдэмтдийн төлөөлөгчид оролцож монгол судлалын талаар илтгэлүүд тавьж байжээ. БНХАУ дахь Монгол судлалын ажил ийм байдлаар хөгжиж байсан юм.

Гэтэл 50-иад оны эцэс 60-аад оны эхээр Мао Зэдуны их гүрний дээрэнгүй бодлого давамгайлж ирсэн үед монгол судлалын ажил хөгжиж байсан замаасаа бүрмөсөн хазайж, Монгол судлалыг түүхийн үнэнд биш, зөвхөн Маогийнхны бодлогод тааруулж хийх болжээ. Тэд ийм ажлыг хийхдээ XIII зуунаас өмнөх үеийн монголын түүхийг бүр мөсөн үгүйсгээд Чингис хаан тэргүүтэй монголын байлдан дагуулагчдын түүх болон манж Чин улсын байлдан дагууллыг шагшин магтах замаар гаж буруу үзлийг хөхүүлэн дэвэргэх болсон юм.

Энэ үеэс Өвөр Монголын өөртөө засах орны Монгол судлаачид хэдийгээр Маогийн үндэсний дээрэнгүй бодлогод судалгааныхаа ажлыг тохируулж байсан боловч монгол хэл судлах, монголын түүхийн сурвалж ба тулгуур бичгийг эмхтгэн цэгцэлж хэвлүүлэх, гадаадын монгол судлалын ном зүйг бэлтгэх ажлаа орхихгүй үргэлжлүүлж байжээ. Өвөр Монголын Их Сургуулийн хэлний шинжээчдийн ажлыг үр дүн болох «Орчин үеийн монгол хэл» хэмээх зохиол 1964 онд хоёр дэвтрээр хэвлэгджээ. Мөн одоо хүртэл өргөн хэрэглэгдэж байгаа «Хятад-монгол толь бичиг» 1963 онд зохиогджээ. 1962—1965 онд Өвөр Монголын их сургуулийн монголын түүх судлах тасаг «Монголын түүх судлалын лавлах материал» нэртэй дотоодын хэрэгцээнд зориулсан хэвлэгдээгүй 24 дэвтэртэй цувралыг зохиожээ.² Мөн 1962 онд Хөх хот дахь Өвөр Монголын түүхийн хүрээлэн «Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойд зориулсан Монголын түүхийн эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн түүврийг» эмхтгэжээ. 1964 онд тус Их сургуулийн монголын түүх судлах тасгаас эрхлэн түү-

² Schwarz, Henry C. *Mongolian Studies in China "Zentralasiatische studien"* 1980, 14/1 p. 214

хийн сурвалж бичгийн материалд тулгуурлан чулуун зэвсгийн үеэс Мин улсын үеийг хамарсан «Монголын түүхийн материалын товч цуглуулга», «Манж Чин улсын засгийн газраас Монголын талаар явуулсан бодлого» хэмээх хоёр эмхтгэл хэвлэн гаргажээ.³ 1966 оноос БНХАУ-д, ялангуяа Өвөр Монголд «соёлын хувьсгалын» нугалаа завхрал дээд цэгтээ тулж Өвөр Монголын нийгэм-соёлын үндэсний олон тооны зүтгэлтнүүд, эрдэмтэд хэлмэгдэж, урьд өмнө хэвлэгдсэн эрдэм шинжилгээний ном хэвлэл шатаагдаж, сэтгүүл шинээр хэвлэхийг бүрмөсөн хаажээ. Чухам энэ үед БНХАУ-д монгол судлалын ажил бүрмөсөн тасрах аюулд хүрчээ.

«Соёлын хувьсгалын» алдаа завхралыг засах уриан дор 70-аад оны эхээр Хятад дахь монгол судлалын ажлыг дахин эхлэн хөгжүүлэх төлөвтэй болов. Гэхдээ Мао Зэдуны их гүрний дээрэнгүй бодлого хэвээр үргэлжилж байсан болохоор Монголын түүхийг эрээ цээргүй завхруулан гуйвуулах байдлаар эхлэв. Үүнд ЗХУ, БНМАУ, социалист Вьетнам болон бусад хөрш зэргэлдээ улс оронд газар нутгийн өнгөлзлөг хийж, түүнийгээ түүхийн ул үндэстэй болгох оролдлогыг шууд хийж эхлэв. «Соёлын хувьсгалаар» хаагдсан «Вэньу» (Материалын соёл), «Каогу» (Археологи), «Лиши Яньцзю» (Түүхийн судлал) зэрэг түүхийн сэтгүүлүүд 1972, 1974 оноос эхлэн хэвлэгдэж, түүх гуйвуулах ажлыг өргөн далайцтай хийж байна.

1976 онд Мао нас нөгчиж «дөрвийн бүлгийг» зайлуулсны дараа Хятадын удирдлага нийгмийн шинжлэх ухааныг өөрийн зорилгод ашиглахын тул нэлээд уян хатан байдалтай бодлого боловсруулжээ. Олон тооны түүхчид, судлаачдын хилс ялыг цагаатгаж, зохион байгуулалтын ажлыг өөрчлөн шинэчилж, хэвлэн нийтлэх ажлыг эрчимжүүлэв. Энэ бүх өөрчлөлт БНХАУ дахь монгол судлалын ажлыг зохих ёсоор хөнджээ. Чухамхүү энэ үеэс монгол судлалын ажлын өнөөгийн шат эхэлсэн гэж бид үзэж байна. 70-аад оны сүүлчийн хагасаас хятад дахь монгол судлалын ажлыг «чөлөөтэй хөгжүүлэх» гэдэг нэрийдлээр Өвөр Монголын өөртөө засах орноор төвлөж эхлэв. Үүнд:

1. Хятадын гурван ӨЗО, таван мужийн хэл шинжээчдийг багтаасан «Монгол хэл бичгийн хамжилцах дугуйлан» гэгчийг 1975 онд байгуулаад 1978 оны 9-р сард Хөх хотод түүний өргөтгөсөн хурлыг хийж тус дугуйлангаас 1978 оноос 1985 он хүртэл хийх ажлын төлөвлөгөөг баталсан байна. Үүний дараа 1979 оны 10, 11-р сард СУАР-ы төв Үрэмч хотод болсон тус дугуйлангийн ээлжит хуралдаанаас монгол хэл бичгийн шинжилгээний нийгэмлэгийг хятадад байгуулж, түүний дүрмийг батлан, нийгэмлэгийн хэрэг эрхлэгчдийн даргаар Бээжин дэх Үндэстний эвлэлийн хорооны хариуцлагатай ажилтан Шаравсэнгээг сонгожээ. Хурлаар монгол хэл бичгийн талаар ойрын хугацаанд хийх судалгааны ажлын зорилт, монгол хэлний шинжлэлийн онол, монгол хэлний үсгийн дүрмийн тухай болон толь бичиг зохиох зэрэг асуудлыг хэлэлцжээ. Хурлаас Өвөр Монголын Шулуун хөх хошууны цахар аялгууг Хятад дахь монгол хэлний үндсэн аялгуу болгохоор тогтжээ. Ийнхүү хэл шинжээчдийн ажлыг зохицуулах нэгэн төв байгуулснаас гадна монгол хэл шинжлэлийн талаар зарим ном, бүтээл нийтэлжээ. Өвөр Монголын их сургуулийн судлаачид «Монгол хэлний зүй» гэсэн зохиолыг 1978 онд монгол хэлээр хэвлүүлжээ. Монгол хэлний толь бичиг зохиох талаар нэлээд ажил хийж 1976 онд «Монгол-хятад толь», 1977 онд «Монгол хэлний зөв

³ Мөн тэнд. Р. 215.

дуудлага, зөв бичлэгийн толь» шинээр зохиосноос гадна 1956 онд анх хэвлэгдсэн «Монгол хэлийг утгаар ангилсан толь бичгийг» 1978 онд дахин хэвлэжээ.

2. Бүх Хятадын үндэстний цөөнхийн уран зохиолын түүх найруулан бичих хуралдаан 1979 оны 2-р сард Куньмин хотод болж тэдний уран зохиолыг судлах ажлыг эрчимжүүлэх шийдвэр гаргажээ. Энэ шийдвэрийн дагуу мөн оны 12-р сард Хөх хотод Хятад дахь монгол утга зохиолын эрдэм шинжилгээний нийгэмлэг байгуулах хурал болж, уг нийгэмлэгийн дүрмийг батлан цаашдын судалгааны төлөвлөгөөг хэлэлцжээ. Хурлаас монголын утга зохиолын судалгааны түвшинг дээшлүүлж дэлхийн тэргүүний хэмжээнд хүргэх зорилт дэвшүүлж, Эрдэнэтогтох, Гаваа, Бөх нарын 4 хүнийг нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүдээр сонгожээ.

Одоогийн байдлаар Монголын уран зохиол судлах ажил нь ардын аман зохиол цуглуулж эмхтгэх, монголын уран зохиолын түүх бичих, хуучин дурсгалт бичгүүдийг хятад, монгол хэлэнд орчуулах, тайлбар судалгаатай хэвлүүлэх ажлыг голчлон хийж байна. Үүнд: В. Инжинашийн «Нэгэн давхар асрыг» 1979 онд, «Хөх судрыг» 1979 онд гурван ботитой дахин хэвлүүлснээс гадна «Шагдар солиотыг» 1972 онд (анх 1959) дахин хэвлүүлсэн байна. Мөн Өвөр Монголын Их сургууль, БДС-ийн судлаачдын хамтын бүтээл «Монгол үндэстний эртний уран зохиол» гэсэн томоохон бүтээлийг 1978 онд нийтлүүлсэн байна. Монголын сурвалж зохиолуудын дотроос «Монголын нууц товчооны» талаар судалгаа явагдаж байна. Даожуньтибу (Гэвагийн бичгийн нэр) «Нууц товчоог» шинээр орчуулж, товч тайлбар зүүлттэйгээр 1979 онд хэвлүүлжээ. Сүүлийн жилүүдэд «Жангар», «Гэсэрийн» судалгаа эрчимтэй явагдаж, 1983 онд «Жангарын» 15 бүлгийг хятад хэлээр орчуулан Бээжинд хэвлэжээ.

3. 1982 оны 7-р сарын 14-ний Синьхуа агентлагийн мэдээнээс үзвэл монголчуудын философийн түүх ба нийгмийн үзэл санааг судлах анхны шинжилгээний группийг Өвөр Монголд байгуулжээ. Философийн салбарт 30-аад жил багшлаж, судалгааны ажил хийж ирсэн 55 настай Өвөр Монголын нэрт философич Мөнхбат 101 гишүүнтэй группийг тэргүүлэх болжээ. Эрдэмтэд, судлаачдаас гадна 10 гаруй оюутныг багтаасан энэ группийн гишүүдийн ихэнхи нь монголчууд байна. Тэд групп байгуулагдахын өмнө болсон симпозиум дээр монголын түүхийн асуудлуудаар 100 шахам илтгэл тавьжээ.

Энэ групп нь монгол, төвд, манж ба хятад хэл дээр бичигдсэн уран зохиол, түүх, одон орон, тооны ухаан ба шашны талаархи 1000 шахам ихээхэн тархай бутархай эх сурвалжийг эмхтгэх ажээ. Монголын философийн судлал нь түүхийн үе шат, түүхэн хувь хүн, түүх шастир ба тусгай сэдвүүдийн судалгаанаас бүрдэнэ гэж групп үзжээ. Чингис, Хубилай хаан болон XIX зууны монголын зохиолч Инжинаш нарыг хувь хүнийх нь хувьд онолын үүднээс судлах ажлыг энэ групп бас хийх ажээ. Сэдвийн судалгаа нь улс төр, үзэл суртлын талаар голлож Чингис хааны цэргийн стратеги, түүнийг тэнгэрээс заяагдсан тухай үзэл болон ардын дуу, яруу найраг ба монголын уламжлалт эмнэлэг зэргийг хамарч байна.

4. Хятадын одоогийн монгол судлалын гол агуулгыг илэрхийлж байгаа салбар бол Монголын түүх судлал юм. Хөрш зэргэлдээ орнууд, түүний дотор БНМАУ-ын газар нутагт өнгөлзөх «хууль ёсны эрхээ» түүхийн үүднээс үндэслэх зорилгоор Монголын түүхийг гуйвуулан завхруулах кампанийг маоист түүхчид нэг биш удаа явуулж ирсэн

билээ. Мөн хятадын ард түмнийг, ялангуяа залуу үеийг үзэл санааны хувьд мунхруулж, улмаар дэлхийн олон нийтийг тэр үзлээрээ төөрөгдүүлэхэд тэд нийгмийн шинжлэх ухаан юуны өмнө түүхийн шинжлэх ухааныг онцгой ашиглаж байна.

1975 онд Өвөр Монголын Их сургуулийн монгол хэл, уран зохиолын тэнхимээс эрхлэн «Монголын түүх судлалын товч тойм ба монголын түүх судлалын салбар дахь олон улсын хурц өрсөлдөөн» гэсэн нэртэй орос, япон болон өрнөдийн хэл дээрхи ном зүйн лавлахыг хэвлэсэн нь монголын түүх судлалын ажил дахин сэргээх анхны шинж тэмдгийн нэг болов. Монгол үндэстний эрт дээр үеэс эдүгээг хүртэл түүхийн бүх үе шатыг хамарсан бөгөөд Монголыг Хятадын түүхийн хавсарга гэж үзсэн хятад төвийн үзлээр бичигдсэн «Монгол үндэстний товч түүхийг» 1977 онд, «Хятадын эртний хойт нутгийн үндэстнүүдийн товч түүхийг» 1978 онд тус тус хятад, монгол хоёр хэл дээр хэвлэн түгээжээ.

1979 оны 3-р сард ӨМӨЗО-ы Нийгмийн ШУА-ийг (НШУА) байгуулж, түүний бүрэлдэхүүнд Монголын түүхийн хүрээлэн, хэл бичгийн хүрээлэн, уран зохиолын хүрээлэнг өөрчлөн зохион байгуулж, эдийн засгийн хүрээлэн, философийн хүрээлэн, үндэстний онол судлах тасгийг сэргээн ажиллуулжээ. Үүний дараа Бээжин, Хөх хот зэрэг газарт тархай бутархай явагдаж байсан монголын түүх судлах ажлыг зохицуулах төв байгуулах зорилгоор 1979 онд «Монголын түүх судлах Хятадын нийгэмлэг»-ийг үндэслэсэн анхдугаар их хурал Хөх хотод хуралджээ. Тус их хурал 8-р сарын 5-наас 8 өдөр хуралдаж 12-нд ажлаа дуусгажээ.⁴ Хуралд Хятадын Монгол судлаач, хэвлэлийн ажилтан нар нийт 127 хүн оролцжээ. Хуралд ӨМӨЗО-ы нам, захиргааны удирдах ажилтнууд оролцож Хувьсгалт Хорооны дарга Кун Фэй нээлтийн, Намын хорооны нарийн бичгийн дарга Вэн Цзэ хаалтын үг хэлжээ. Мөн хуралд хятадын НШУА-ийн удирдах ажилтан Мэй Гуанхуа, ӨМӨЗО-ы НШУА-ийн ерөнхийлөгч Хао Фань, дэд ерөнхийлөгчид Лу Чжихао, Гэваа, Хэрлэн, ӨМӨЗО-ы Их сургуулийн ректор Юй Бэйчэнь, БДС-ийн ректор Төмөрбагана нар оролцжээ. Хурал дээр Хятадын НШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн орлогч захирал Лянь Ханьбин, Үндэстний цөөнхийг судлах Хүрээлэнгийн орлогч захирлууд болон Монголч эрдэмтэн Вэн Дуцзянь, Хуан Цзинтао нар үг хэлсэн байна.

Хурлыг ӨМӨЗО-ы НШУА, Хятадын НШУА-ийн Түүхийн, Үндэстний цөөнхийг судлах хүрээлэн гурваас хамтран зохион байгуулжээ. ӨМӨЗО-ы НШУА-ийн ерөнхийлөгч Хао Фань хурлыг нээж хэлсэн үгэндээ их хурлын гол зорилтыг «Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийг байгуулан, гүйцэтгэх хороог сонгох, мөн анхны эрдэм шинжилгээний санал солилцон, Монголын түүх судлалын дэлхийн төвийг өөрийн оронд (БНХАУ—Ц.Б.) аажмаар шилжүүлэн авчрах асуудлаар санал солилцон, аль болох богино хугацаанд чанар сайтай «Монголын нэвтэрхий түүхийг» зохион гаргах асуудлыг хэлэлцэх» тухай тодорхойлжээ.⁵

Өвөр Монголын НШУА-ийн дэд ерөнхийлөгч Гэваа «Монголын түүх судлах төв байгуулах хэтийн төлөв» гэсэн үндсэн илтгэлийг тавьж хуралд хэлэлцүүлжээ. Тэрээр Монголын түүх судлалын объектуудыг

⁴ «Чжунго мэнгүшисюэхуй чэньлидахуй зинианжикан» («Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн анхдугаар хурлын илтгэлийн эмхтгэл»), Хөх хот, 1979.

⁵ Мөн тэнд. 1-р тал.

тодорхойлоод «Монгол үндэстний нэвтэрхий түүхийг» зохиосноор «Хятадын нэвтэрхий түүхийн» агуулгыг баяжуулахад хувь нэмэр оруулах юм гэв.⁶ Дэлхийн монгол судлалын ерөнхий байдлыг задлан шинжлээд БНХАУ-ын Монгол судлалын боловсон хүчин, материал хэрэглэгдэхүүний асуудал, энэ салбарт хамтран ажиллах асуудал, арга барил, удирдлага болгох үзэл санааны талаар ярьсан байна. Вэн Дуцзянь «Манай орон дахь Монголын түүхийн судлалын ажлыг бэхжүүлэе» гэсэн илтгэлдээ Гэваагийн хэлсэнчилэн дэлхийн монгол судлалын төвийг Хятадад, Хөх хотод шилжүүлэн авчрах зорилтыг боломжтой гэж тэмдэглээд, Хятадын болон гадаадын монгол судлалын байдал, ялангуяа Хятадад энэ судлалыг цаашид хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний талаар ярьжээ.⁷ Үүнд : 1-рт; Монгол судлалын суурийг тавихын тулд Монгол хэл дээрх тулгуур сурвалж «Монголын нууц товчоо», «Эрдэнийн товч», том бага «Алтан товч», шинээр олсон «Алтан ханы намтар» зэргийг эмхэлж цэгцлэх, перс хэл дээрх материал «Дэлхийг байлдан дагуулагчийн түүх», «Судрын чуулган» зэргийг орчуулж тайлбарлах, хятад хэл дээрх сурвалж бичиг, ялангуяа «Юан улсын судрын» судалгааг эрчимжүүлэхийн чухлыг онцлон заажээ. 2-рт : Боловсон хүчнийг бэлтгэх асуудал хурц тавигдаж байна. Учир нь ӨМӨЗО-д зөвхөн монголын түүх судлаачид 40 орчим байна. 3-рт: Судалгааны материалын төв байгуулах, тухайлбал катологи зохиох асуудлыг дэвшүүлэв.

4-рт: хэвлэлийн төвтэй болох, үүнд Өвөр Монголын ардын хэвлэлийн хороонд тусгай редакц байгуулах, эсвэл Өвөр Монголын НШУА-ийн дэргэд нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн газар байгуулах санал дэвшүүлэв.

Хуралд оролцсон монголын түүхийн судлаачид нийт 77 илтгэл тавьсан байна. Үүнд монгол үндэстний гарал үүсэл, Монголын боол эзэмших ёсны тухай, Чингис хааныг үнэлэх хэдэн асуудлууд, Юан улсын нийгэм, эдийн засаг, соёлын асуудлууд Зүүнгарын түүхэн хүмүүсийг үнэлэх асуудал, Чин улсын үеийн Монголын өртөө замын тухай, Өвөр Монголын ардын хөдөлгөөний удирдагчдын тухай сэдвүүд багтжээ.

Хурлаар зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн Гүйцэтгэх Хороог 30 хүний бүрэлдэхүүнтэй сонгожээ. Мөн Тайваний монгол судлаачдад зориулан Гүйцэтгэх Хороонд хэдэн асуудал үлдээжээ. Гүйцэтгэх Хорооны даргаар Вэн Дуцзянь, орлогч даргаар Гэваа, Хан Жулин⁸, Хуан Цзинтао, хариуцлагатай нарийн бичгийн даргаар Лу Минхуйг сонгожээ. Тус нийгэмлэгийн шинж чанар, үүрэг зорилт, гишүүдийн эрх үүрэг, зохион байгуулалт, мөнгөн орлогын асуудлыг тусгасан нийгэмлэгийн дүрмийг баталсан байна.

8-р сарын 12-нд тус хуралд оролцсон нийт төлөөлөгчдийн нэрийн өмнөөс Монголын түүхийн сурвалж материалын төв ба хэвлэлийн төв байгуулах, «Монголын түүхийн судлал» хэмээх тогтмол хэвлэлтэй болох, хувьсгалын ахмад үеэр дурсамж бичүүлэх асуудлыг багтаасан тусгай уриалгыг гаргасан байна.

⁶ Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн анхдугаар хурлын илтгэлийн эмхтгэл. Хөх хот. 1979. (хятад хэл дээр) 20-р тал.

⁷ Мөн тэнд. 14—19-р тал.

⁸ Нанкины Их сургуулийн профессор Хан Жулин 1983 оны 4-р сарын 7-нд 80 насандаа нас нөгчжээ. (Гуанмин жибао, 1983.IV.19)

Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн II хурал 1980 оны 7 дугаар сарын 15-нд Хөлөнбуйрын Хайларт нээгдэн 12 өдөр ажлаа үргэлжлүүлэн, 27-нд Манжуур хотод хаажээ.⁹ Тус хуралд Хятадын 13 хот, муж, ӨЗО-оос ирсэн 185 монголын судлаачид оролцож, 66 илтгэл тавьжээ. Нийгэмлэгийн орлогч дарга Хуан Цзинтао нээлтийн хуралдаан дээр хэлсэн үгэндээ нийгэмлэг байгуулагдсанаас хойших нэг жилийн ажлыг дүгнээд, ээлжит хурлын гол сэдэв нь Монголын түүхэн хүмүүсийг үнэлэх, Монголын нийгмийн шинж чанар ба Монголын түүхийн үечлэлийн асуудлыг хэлэлцэх явдал гэж тодорхойлов. Хурал дээр нийгэмлэгийн нарийн бичгийн дарга Лу Минхуй тайлан илтгэл тавив. Хуралд хэлэлцсэн асуудлуудаас монголын эртний нийгмийн шинж чанарын тухай асуудал олны анхаарлыг ихэд татаж судлаачдын санал хоёр хуваагджээ. Нэг талаас Гэваа, Гао Вэндэ нар 1206 оноос өмнө монголын нийгэм нь боол эзэмшигчдийн байгуулалд шилжсэн, монгол үндэстэн түүхийн энэ шатыг дайрч өнгөрсөн гэв. Нөгөө талаас Чэнь, Куан Юйчэ, Бай Цуйцин нар судлаачид монголын нийгэмд гэрийн боолчууд байсан боловч зонхилох байр эзлээгүй, иймд боол эзэмшигчдийн нийгэм гэж тодорхойлж болохгүй гэсэн саналыг дэвшүүлэв.

Тус хурал дээр тавигдсан нийт 66 илтгэлийн 40 гаруй нь түүхэн хүмүүсийг үнэлэхэд чиглэгдсэнээс үзэхэд дээрх асуудал хятадын судлаачдын анхаарлыг ихэд татаж буйг гэрчилж байна. Тухайлбал Чингис хаан, Елюй Чуцай, Хубилай нараас эхлэн Зүүнгарын түүхэн хүмүүс, Галдан, Галданцэрэн, мөн Утай ван, Шинэ лам нарын амьдрал үйл ажиллагаанд зориулагдсан илтгэлүүд оржээ. Тус хурлаас Чингис хааныг «тодорхой түүхэн нөхцөлд төрсөн монголын үндэстний гарамгай төрийн зүтгэлтэн, цэргийн жанжин байсан. Тэрээр Монголыг нэгтгэн, хэд хэдэн нийгмийн шинэтгэл хийж Монголын нийгмийн улс төр, эдийн засгийн хөгжлийг түргэтгэсэн нь тухайн үеийн бодит шаардлагад тохирч байсан» гэж дүгнэхийн хамт «Тэр болон түүний замгамжлагч Хубилай нар Хятадыг нэгтгэсэн. Юан, Мин, Чин улсын 600 жилийн туршид хятадын тайван тогтвортой байдлын үндсийг тавьсан» гэсэн үнэлэлт өгчээ.

Хурал дээр бас БНХАУ дахь Монголын түүх судлалын боловсон хүчин бэлтгэх, материаллаг баазыг бэхжүүлэх асуудлыг авч хэлэлцжээ. Мөн «Монгол үндэстний нэвтэрхий түүх» номыг зохиох ба «Монголын түүхийн судлал» гэсэн тогтмол хэвлэлтэй болох асуудлаар санал солилцжээ. Тэр ч байтугай БНХАУ дахь монголын түүхийн судлалыг түргэнээр дэлхийн тэргүүний хэмжээнд хүргэх зорилтыг хөндөөд гадаадын монголч эрдэмтдийн ололтыг тусгасан «Монголын түүхийн мэдээллийг» ирээдүйд эрхлэн хэвлэх тухай ярилцжээ.

Монголын түүх судлах хятадын нийгэмлэгийн 1981 оны ээлжит хурал 1981 оны 8 дугаар сарын 15-наас 20-нд Үрэмчид болж хятадын талаас 121 судлаачид оролцсоноос гадна Япон, ХБНГУ, АНУ-аас уригдан ирсэн 8 монголч эрдэмтэн оролцжээ.¹⁰ Хурлаар нийт 49 илтгэлийг авч хэлэлцсэн байна. Монголын түүхийн судлал нь дэлхийн нийтийн чанартай гэдгийг хүлээн зөвшөөрөөд, энэ судлалын ололт амжилт чиглэлийг ойлгох зорилгоор анх удаа гадаадын эрдэмтдийг урин Монголын түүх судалж буй байдлаа харилцан танилцуулах, туршлага солилцох явдлыг хурлын үндсэн агуулга болгожээ. Хурал

⁹ Чжунго мэньгушисюэхуй лунвэнь сюаньчжи (Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн хурлын илтгэлийн шилмэл түүвэр) Хөх хот, 1981.

¹⁰ Минцзу Яньцзю, 1981, № 6.

дээр Өвөр Монголын НШУА-ийн Монголын түүхийн хүрээлэнгийн ажилтан Жу Фэнь, Лу Минхуй, Өвөр Монголын Их Сургуулийн түүхийн тасгийн Лин Чэнь, Нанкины Их сургуулийн түүхийн факультетын Чэнь Дэчжи, Синьцзяны НШУА-ийн Төв Азийн хүрээлэнгийн Ван Чжилай нар өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол, Юан улсын түүхийг судалсан байдлыг тус тус танилцуулжээ. Тэд Монгол, Юан гүрний түүх судлах эрдэм шинжилгээний байгууллагууд, судлаачдын отряд, ном хэвлэл, мөн хятадын судлаачдын анхаарлыг ихэд татаж буй асуудлуудыг танилцуулжээ.

Японы Тайсё Их сургуулийн Мураками Масацугу нарын 4 монголч эрдэмтэд Японд Юан, Мин, Чин улсын болон орчин үеийн Монголын түүхийг судлаж буй байдлыг товч танилцуулжээ. Мөн ХБНГУ-ын Бонны Их сургуулийн Хайссиг, АНУ-ын Харвардын их сургуулийн Фуллич, Вашингтоны Их сургуулийн Чэнь Сюэлин, Баруун Вашингтоны Их сургуулийн Шварц Генри Гюнтер нар Европ, Америкт Монгол, Юан гүрний түүхийг судалж буй байдлын талаар ярьжээ. Хурлын явцад хятадын ба гадаадын эрдэмтэд монгол үндэстний гарал үүсэл, Юан улсын цэргийн систем, тамгач цэрэг, Өөлд Монголын түүх зэрэг асуудлуудаар санал солилцжээ. Мөн түүхийн материалыг цуглуулж цэгцлэх, судалгааны арга барилын асуудлаар туршлага солилцсон байна.

Монголын түүх судлах Хятадын нийгэмлэгийн ээлжит IV хурал Юньнань мужийн төв Куньмин хотод 1983 оны 9-р сарын 16-наас 22-нд хуралджээ.¹¹ Хуралд нийт 100 орчим судлаачид оролцож, 58 илтгэл хэлэлцжээ. Үүнд Хубилай хаан хан үндэстний хуулийг хэрхэн хүлээж авсан тухай, Чингис хааны цэргийн бодлогын тухай илтгэлүүд оржээ. Зүүнгарын түүхэн хүмүүсийг үнэлэх асуудлаар зарим «шинэ санал» дэвшүүлсэн гэдэг нь анхаарал татаж байна. Оростой харилцаатай байсан Зүүнгарын түүхэн хүмүүсийн үйл ажиллагааг «хагалан бутаргах», «урван тэрслэх» гэж үздэг бөгөөд Зүүнгарын феодалуудаас Чин улстай харилцаж байсан харилцааг дан зөрчил, тэмцлээр дүүрэн гэж үздэг байсан урьдын баримтлал, үнэлэлт дүгнэлтээ бага зэрэг хянан засварлажээ. Зүүнгарын зарим феодал Оростой болгоомжтой харьцаж байсан, Хятадтай худалдааны харилцаа хөгжүүлэхийг оролдож байсныг өлгөн авч Хятадын «их гэр бүл» гэгчийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан гэж өндөр үнэлэхийг оролджээ. Энэ нь Зүүнгарын феодалуудын үйл ажиллагааг бүрмөсөн үгүйсгэсэн явцгүй ерөөсгөл үзлээ бага зэрэг засварлан өнөөгийн үндэстний бодлогын зорилгод зохицуулан ашиглах гэсэн оролдлого бололтой.

Сүүлийн жилүүдэд хятадын монгол судлаачид урьд нь хийдэггүй байсан монголын хууль цаазын дурсгалт бичгийн судалгааг сонирхох болжээ. Тухайлбал «Алтан ханы хууль», «Цагаан хусны үйсэн дээр бичсэн хууль», «Монгол-Ойрадын хууль» зэргийг хятад хэлэнд орчуулж байгаа ажээ. Гэвч энэ асуудалд мөн л их гүрний дээрэнгүй үзлээс хандаж «Монголын орон нутгийн хууль нь хятадын хуулийн нэг хэсэг» гэж бичжээ.

Ийнхүү сүүлийн хэдэн жилд БНХАУ дахь Монголын судлал, ялангуяа түүхийн судлал нэлээд идэвхжих хандлагатай болж зохион байгуулалтын хувьд бэхжин, зохицуулах нэгэн төвтэй болж, судалгааны хүрээ нь өргөжиж байна. Хятадын хэвлэлийн мэдээгээр одоо Хятадад монголчуудын түүх судлалын тусгай мэргэжилтэн 120 гаруй хүн бай-

¹¹ «Жэньминь жибао», 1983.XI.7.

гаагаас тэдний 30% орчим нь монгол үндэстэн буюу хятад бус ард түмний гаралтай эрдэм шинжилгээний ажилтнууд байна.¹² Мөн 50-иад оны дунд үед ихээхэн өрнөж байгаад тасарсан түүхийн холбогдол бүхий материалыг эрж хайх, цуглуулж цэгцлэх, эмхтгэн хэвлэх ажилд дахин анхаарал тавьж байна. Түүнээс гадна гадаадын монголч эрдэмтэд ба эрдэм шинжилгээний байгууллагатай судалгааны солилцоо хийх талаар арга хэмжээ авах болов.

Эцэст нь хэлэхэд БНХАУ дахь Монголын түүх судлалын судалгааны чиглэлүүдийг авч үзвэл дараах асуудлуудад хятадын судлаачид онцгой анхаарлаа хандуулж байна. Үүнд: 1. Монгол үндэстний гарал үүсэл, 2. Монголын олон аймгуудын нүүдлийн овгийн байгууллын бүтэц ба монголын нийгэм боол эзэмшигчдийн байгууллыг дайрч өнгөрсөн эсэх, 3. Монголын эзэнт улсаас удаа дараа явуулж байсан байлдан дагууллын шинж чанар ба зорилго, дайны гүйцэтгэсэн үүрэг роль, энэ нь монголын нийгэмд хэрхэн нөлөөлсөн; 4. Монголын эзэнт улс ба Юан гүрний ноёрхлын үе дэх олон газар районы нийгэм-эдийн засгийн хөгжил, соёл, шашны салбарт гарсан өөрчлөлт, 5. Юан гүрний үеийн улс төр, эдийн засаг, соёл, тариачны бослого болон цөөнх үндэстний байдал, 6. Монгол үндэстний хөгжлийн янз бүрийн шатан дахь түүхэн хүмүүсийн үнэлгээ, 7. Шинэ үеийн монголын нийгмийн хөгжил ба үндэстний хөдөлгөөн зэрэг асуудлууд хамрагдаж байна.

Эд бүхэн нь БНХАУ-д монгол судлалыг эрчимжүүлэх нэрийдлээр монгол судлалын төвийг Хятадад шилжүүлэх, Монголын түүхийг хятадын их хан үндэстний өнгөлзөх бодлогод нийцүүлэн завхруулж гуйвуулах, ингэснээр юуны өмнө БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг үнэн хэрэгтээ үгүйсгэж байгаагаа түүхийн «ул үндэстэй» болгох гэж буйд хятад дахь Монгол судлалын гол зорилго чиглэж байна.

МОНГОЛОВЕДЕНИЕ В КНР И ЕГО ЦЕЛЬ

(Р е з ю м е)

В статье рассматриваются основные этапы развития монголоведения в КНР, начиная с периода образования КНР до начала 80-х гг. Автор считает, что с конца 40-х гг. среди китайских монголоведов существовали два основных направления. Одни стремились правдиво отражать в своих трудах историю монгольского народа, исходя из коренных интересов монголов, а другие в угоду великоханьскому шовинизму фальсифицировали исторические факты с тем, чтобы представить историю Монголии как составную часть истории Китая.

С конца 50-х гг. и начала 60-х гг., когда маоистское руководство Китая перешло к открытой шовинистической политике в отношении соседних стран, второе направление явно преобладало в монголоведении Китая и продолжает доминировать и в наши дни, правда с некоторыми коррективами. В статье значительное место отведено нынеш-

¹² Лу Минхуй «Хятад дахь монголын түүх судлалын хэдэн асуудал» (Жэньминь жибао, 1981.VIII.10)

нему состоянию монголоведения в КНР, исследованиям в области монгольского языка и литературы, философии и общественной мысли. При этом особое внимание уделяется изучению в КНР истории Монголии.

По мнению автора с середины 70-х гг. в КНР возобновляется изучение истории Монголии, выпускаются периодические издания, публикуются монографии и сборники статей по монголоведению.

Созданное в 1979 г. в Хух-хото общество по изучению истории Монголии является своего рода координационным центром монголоведения КНР. Оно провело уже 4 симпозиума. Как видно из материалов симпозиумов, общество ставит перед китайским монголоведением цель перенести центр мирового монголоведения в КНР, в частности в Автономный район Внутренняя Монголия. Автор статьи дает частичный анализ докладам симпозиумов, что позволяет в общих чертах судить о некоторых тенденциях, наметившихся в китайском монголоведении на нынешнем этапе.